

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ
/төсөл/**

2015.04.27

Дугаар...

Алтай хот

Төсөл сонгон шалгаруулах журам батлах тухай

Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Үйлдвэржилтийг дэмжих ажлын хүрээнд импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байр бий болгох зорилгоор **“Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлттэй зээл олгоход баримтлах төсөл сонгон шалгаруулах журам”**-ыг 1 дүгээр, **төслийн иж бүрдлийг** 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгох зээлийн хүүг жилийн 3 хувиар тогтоож, зээл олгох ажлыг холбогдох хууль тогтоомж болон **“Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлттэй зээл олгоход баримтлах төсөл сонгон шалгаруулах журам”**-ын дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ДЭЛГЭРЖАРГАЛ

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ
ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ
ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ /төсөл/**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилтын хүрээнд орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлттэй зээл олгоход энэхүү журмыг баримтална.
- 1.2. Хөнгөлттэй зээлийг импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинээр ажлын байр бий болгоход зарцуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулах замаар олгоно.
- 1.3. Төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулна.

Хоёр. Хөнгөлттэй зээлийн эх үүсвэр, зээлийн нөхцөл

- 2.1. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид олгох дэмжлэгийн эх үүсвэр нь орон нутгийн хөгжлийн сангаас баталсан хөрөнгө байна.
- 2.2. Хөнгөлттэй зээл нь 3 жилийн хугацаатай, үндсэн зээлээс чөлөөлөгдөх хугацаа 6 сар байна.
- 2.3. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хуваарийг Санхүү, төрийн сангийн хэлтэс хянах бөгөөд зээлийн гэрээгээр зохицуулна.
- 2.4. Санхүүжилтийг зөвхөн төгрөгөөр олгоно.
- 2.5. Төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаар шалгарсан төслийн зээлийг Засаг даргын захирамж гарган, зээлийн гэрээ байгуулж олгоно.
- 2.6. Нэг аж ахуйн нэгж байгууллагад олгох зээлийн хэмжээ 100.0 /нэг зуун/ сая төгрөг хүртэл байна.

Гурав. Хөнгөлттэй зээлд хамрагдах аж ахуйн нэгжид тавигдах шаардлага

- 3.1. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгж нь орон нутагт сүүлийн 3-аас доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байна.
- 3.2. Аж ахуйн нэгжийн сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дундж 300 сая төгрөгнөөс дээш байна.

3.3. Үйлдвэрийн өөрийн өмчлөлийн байртай байна.

3.4. Бусад эх үүсвэрээс үйлдвэрлэлээ өргөтгөх, шинэчлэхээр зээл аваагүй байх.

3.5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудаас эрэмбэлэгдсэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дараах үйлдвэрийн чиглэлүүд байна.

Үүнд: - Чулуу боловсруулах үйлдвэр,

- Хөөсөнцөрийн үйлдвэр,

- Төмөр бетоны үйлдвэр

- Шохой боловсруулах үйлдвэр,

- Будагны үйлдвэр

- Цементийн үйлдвэр

- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах /Ингэний сүү боловсруулах/ үйлдвэр

- Мах боловсруулах үйлдвэр,

- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр

- Арьс шир боловсруулах үйлдвэр

Дөрөв. Төсөл хүлээн авах

4.1. Төсөл хүлээн авах хугацааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж, Хөгжлийн бодлогын хэлтэс хүлээн авна.

4.2. Шаардлага хангасан төслийг төсөл сонгон шалгаруулах комиссын хуралд оруулна.

4.3. Шалгараагүй төслийг 10 хоногийн дотор хуулийн этгээдэд буцаан албан бичгээр хүргүүлнэ.

4.4. Төсөл нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан төслийн иж бүрдлийг хангасан байна.

Тав. Үүрэг хариуцлага, хяналт

6.1. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлсээс хяналт тавина.

6.2. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хэрэгжилтийн явцын мэдээг улирал тутам Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ.

6.3. Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавина.

6.4. Төсөлд олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд арилжааны банкны хүүгээр тооцож зээлийг эргэн төлүүлнэ. Энэ талаар төсөл эхлэхэд гэрээнд тодорхой тусгана.

ТӨСЛИЙН ИЖ БҮРДЭЛ /төсөл/

ОРШИЛ

Нэг. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл

- 1.1 Төслийн товч агуулга
- 1.2 хуулийн этгээдийн нэр
- 1.3 Үйлдвэрийн байршил
- 1.4 Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнээс өөрийн хөрөнгийн хэмжээ
- 1.5 Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр, төрөл
- 1.6 Төслийн төрөл
- 1.7 Жилийн эргэлт, борлуулалт, экспортод эзлэх хувь
- 1.8 Одоогийн эрхэлж буй бизнесийн талаарх мэдээлэл

Хоёр. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

- 2.1. Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа
- 2.2. Түүхий эдийн чанарын үзүүлэлт
- 2.3. Түүхий эдийн нөөц
- 2.4. Үйлдвэрийн хүчин чадал

Гурав. Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлага

- 3.1. Удирдлагын бүтэц орон тоо
- 3.2. Ажиллагчдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар

Дөрөв. Зах зээлийн судалгаа

- 4.1. Зах зээлийн төлөв байдал\SWOT\ шинжилгээ
- 4.2. Хэрэглэгчдийн тодорхойлолт

Тав. Эдийн засгийн тооцоо

- 5.1. Үндсэн үйлдвэрлэл, нийт орлого
- 5.2. Борлуулалтын орлогын тооцоо
- 5.3. Үйлдвэрлэлийн зардалын тооцоо
- 5.4. Бүтээгдэхүүний өртгийн тооцоо
- 5.5. Төлөвлөж буй борлуулалтын тооцоо
- 5.6. Үйлдвэрлэлийн үр ашгийн тооцоо
- 5.7. Төслийн өгөөж, өртгийн тооцоо

Зургаа. Дүгнэлт

- 6.1. Дүгнэлт

Долоо. Хавсралт

- 7.1. Иргэний баримт бичгийн хуулбар. Баг, хорооны тодорхойлолт
- 7.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- 7.3. Тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг
- 7.4. Зээлийн эргэн төлөлтийн график
- 7.5. Барьцаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбар хувиараа/
- 7.6. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, зураг
- 7.7. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэлтэй бол тус зээлтэй холбоотой баримт/ зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, тодорхойлолт, зээл зарцуулалтын тооцоо/
- 7.8. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан
- 7.9. Татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэс, шүүхийн болон ШШГАлбанаас тодорхойлолт.
- 7.10. Үйлдвэрлэлийн урсгалын зохион байгуулалт болон хөдөлмөрийн нөхцөлийн дүгнэлт МХГ-аас гаргуулсан байна.
- 7.11. Зээлийн өрийн үлдэгдэлтэй бол тус зээлтэй холбоотой баримт бичиг /гэрээ, зээлийн дансны хуулга, зарцуулалтын тооцоо, тодорхойлолт/